

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН
3.0 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ
ЭХЛЭЭГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2023/28-21-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 99890258 Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл гарвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2023 оны 04 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

БҮЛЭГ А. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УЛС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЗОРИЛТОД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

А.1. Зарим төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтод нийцүүлэн төлөвлөөгүй байна.

А.2. Орон нутгийн саналд үндэслээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтыг 2022 оны Төсвийн тухай хуулиар баталсан байна.

БҮЛЭГ Б. УТХО-ААР ХЭРЭГЖСЭН 3,007.8 САЯ ТӨГРӨГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. УТХО-аар хэрэгжих 2,509.5 сая төгрөгийн 6 арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Б.2. Төсөл, арга хэмжээнүүдийг зураг, төсөл, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж хүлээж авсан байна.

Б.3. Барьцаа хөрөнгөнөөс 88.8 сая төгрөгийн санхүүжилтийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр гүйцэтгэгчээс өөр хуулийн этгээдэд олгосон байна.

Б.4. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь барилгын ажлын явцад хяналт хийж ажиллаагүй байгаа нь барилгын ажлын чанарт сөрөг нөлөө учруулах эрсдэлтэй байна.

Б.5. УТХО-аар хэрэгжсэн 3,007.8 сая төгрөгийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

БҮЛЭГ В. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

В.2. Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар барьцаа, магадалшгүй ажлын 12.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
БОАЖС	Байгал орчин аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны сайд
БШСУГ	Боловсрол шинжлэх ухаан соёл урлагийн газар
БХТ	Барилга хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НАНБХАСЗУСТХ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХОТСХТЖ	Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сай
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ҮХ	Үндсэн хөрөнгө
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/19

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төвд тус тус хүргүүлсүгэй.

4. “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2024 оны 01 дүгээр сарын 20-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /З.Даваадорж/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.

7. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /З.Даваадорж/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторм 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/19 дугаар тушаалын хөёрдугаар хавсралт



“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	67/A2270437/ХӨА-2023/28-21-ШТА-ГА	Зөрчил арилгах
2	68/A2270438/ХӨА-2023/28-21-ШТА-ГА	Зөрчил арилгах
3	69/A2270438/ХӨА-2023/28-21-ШТА-ГА	Зөрчил арилгах

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дугаар тушаалаар баталсан аудитын сэдвийг үндэслэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө болон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын дэд төлөвлөгөөний дагуу аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх,
- ❖ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх,
- ❖ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад 2022 онд эрх шилжин хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд хяналт хийсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, дүгнэлт, ашиглалт хүлээн авсан комиссын дүгнэлт, үүрэг даалгавар тэдгээрийн биелэлт, төсөл, арга хэмжээг өмчид хүлээн авсан бүртгэл, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч байгууллага, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан, Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Хатгал, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Улаан-Уул, Баянзүрх сумдыг хамруулж ажилласан болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа,

тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор З.Даваадорж, Н.Гүрбазар нар 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрөөс 04 дүгээр сарын 20-ний өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хөвсгөл аймагт 2022 онд улсын төсвөөс 59,799.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 89 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс: 26,845.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл арга хэмжээг Хөвсгөл аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна.

Тухайн онд төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлсэн 31 төсөл арга хэмжээнээс өмнөх оноос шилжиж ирсэн 19,830.1 сая төгрөгийн 20, шинээр 7,015.0 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ байна.


Хөрөнгө оруулалтын тайлант оны гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн 50-иас дээш хувийг барилга байгууламж, тоног төхөөрөмж эзэлж байна. Төсөл арга хэмжээний ангиллыг графикаар харуулбал:

Хүснэгт №1

Хэрэгжилт	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Хувь
Хэрэгжиж дууссан	15,879.7	23	74
Хэрэгжилт дутуу	9,632.4	5	17
Дараа онд шилжих	200.0	1	3
Хэрэгжээгүй	1,133.0	2	6
Нийт	26,845.1	31	100

График – 1



УТХО-аар 2022 онд хэрэгжихээр эрх шилжсэн ТАХ-г 39 багц болгон 109 удаа худалдан авах ажиллагаа зохион байгуулж 37 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж 2 багцын ХАА тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Худалдан авах ажиллагаанд баримталсан журмыг графикаар харуулбал дараах байдалтай байна.

Эрх шилжсэн 31 төсөл арга хэмжээнээс 29 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 12,439.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.



график-2

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Хөвсгөл аймгийн 2022 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталж 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 10 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна.

Анх баталсан болон тодотгол хийсэн дүнгээр нийт 5,858.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,979.2 сая төгрөгөөр санхүүжих 38 төсөл, арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Төсөл, арга хэмжээний жагсаалт, төсөвт өртгийг Хавсралт № 1-ээр харуулав.


Хүснэгт № 2 /сая төгрөг/

Төрөл	Анх батлагдсан			Төсвийн тодотголоор нэмэгдсэн			Нийт		
	тоо	төсөвт өртөг	санхүүжих дүн	тоо	төсөвт өртөг	санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Шилжих	11	2,570.2	689.2	1	197.5	251.5	12	2,767.7	940.7
Шинэ	4	1,476.8	690.1	22	1,614.3	1,347.8	26	3,091.1	2,037.9
Нийт	15	4,046.9	1,379.3	23	1,811.8	1,599.3	38	5,858.7	2,979.2

Хүснэгтээс харахад нийт ТАХ-г 60 хувь, төсөвт өртгийн 30 хувь, санхүүжих дүнгийн 54 хувийг төсвийн тодотголоор нэмсэн байна.

Төсөл, арга хэмжээнүүдийг хөрөнгө оруулалтын төрлөөр ангилан харуулбал дараах байдалтай байна:

График-3



Их засвар болон барилга байгууламжийн ажил нийт төсөвт өртгийн дийлэнх буюу 81 хувийг эзэлж байна.

Хөрөнгө оруулалтыг хэрэгжиж буй салбараар ангилж үзвэл дараах байдалтай байна.

График-4



Графикаас үзэхэд төрийн байгууллагын тоног төхөөрөмж, ажиллах нөхцөл сайржуулахад хөрөнгө оруулалтын ихэнх хувь нь зарцуулагдсан байна.

Тайлант онд ОНТХО-ын 2,318.7 сая төгрөгийн 27 ТАХ-нд 55 удаа ХАА явуулж 2,152.8 сая төгрөгийн 25 ТАХ-нд гүйцэтгэгч шалгаруулан 2,089.7 сая

төгрөгийн гэрээ байгуулж 63.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна. ХАА-д баримталсан журам болон зарласан хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 3

Тендер шалгаруулалтын журам	Тоо	Төсөвт өртөг /сая төгрөг/	Худалдан авах ажиллагааг зарласан хэлбэр	Тоо	Төсөвт өртөг /сая төгрөг/
Нээлттэй	6	1,416.5	Цахимаар	17	2,095.4
Харьцуулалт	10	608.9	Уламжлалт	6	99.7
Шууд гэрээ байгуулах	11	293.4	Шууд сонгох аргаар	4	123.6
Нийт	27	2,318.7	Нийт	27	2,318.7

Босго үнийг баримтлан шууд худалдан авах журам сонгосон худалдан авах ажиллагаануудад уламжлалт аргаар үнийн санал авах, шууд сонгох аргыг ашигласан байна.

ОНТХО-аар 2022 онд хэрэгжсэн 38 ТАХ-ний 1,471.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ нь өмнөх онуудад хэрэгжиж дууссан ТАХ байсан бол тайлант онд 3,239.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ хэрэгжиж дууссан байна.

Дээрх дүнгээр авч үзвэл 2022 онд хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэл **70.9 хувьтай** байна. Санхүүжилт олгохоор баталсан 2,979.2 сая төгрөгөөс тус онд 33 ТАХ-ний 2,377.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, санхүүжилтийн гүйцэтгэл **79.8 хувьтай** байна.

Тайлант онд 398.8 сая төгрөгийн 7 ТАХ-ний 11 хөрөнгийг Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар холбогдох шатны байгууллага өмчдөө бүртгэж тайлагнасан байна.

БҮЛЭГ 1:

ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ УЛС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЗОРИЛТОД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

А.1. Зарим төсөл, арга хэмжээг улс, орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтод нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцээгүй 315.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Хэрээтийн даваа, Бижийн даваа, Бор бургасны давааны зам засварын зураг төсөв /Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/
2. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл, арга хэмжээний багц-16 компьютер, принтер тоног төхөөрөмж.

Энэ нь Төсвийн хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.5¹ дахь заалттай нийцээгүй байна.

Дунд хугацааны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй 2,724.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18² төсөл, арга хэмжээ баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.2³ дахь заалттай нийцээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдаагүй 3,485.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний 14⁴ багц арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.5 дахь заалтад нийцээгүй байна.

Төлөвлөлтийн уялдаа муу байгаагаас хөдөө аж ахуйн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтуудыг ашиглалт хангалтгүй байна. Тухайлбал:

- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө", Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж гэсэн 4,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний хүрээнд нийлүүлэгдсэн тоног, төхөөрөмжүүд зорилтот бүлэгтээ хүрээгүй, ашиглалт хангалтгүй байна.
- Аймгийн ИТХ-ын шийдвэрээр тоног, төхөөрөмжүүдийн ашиглалт, хадгалалтыг сайжруулах зорилгоор “Хөдөөгийн шийдэл” ОНӨААТҮГ-ийг 3 орон тоотойгоор байгуулан ажиллуулж эхэлсэн боловч одоогийн байдлаар тодорхой үр дүнд хүрээгүй байна.
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслөөс 15.0 сая төгрөгөөр “Хөдөөгийн шийдэл” ОНӨААТҮГ-т оффисын тоног, төхөөрөмж худалдан авсан нь хөрөнгө оруулалтын үр дүнг тодорхой дээрх дүнгээр бууруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хэрэгжих хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны Хөгжлийн бодлогуудад бүрэн нийцүүлж төлөвлөөгүй нь төлөвлөлтийн уялдаа хангахгүй байна.

¹ 29¹.2.5. тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх

² Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хавсралт №2-оор үзүүлэв

³ 29.3.2. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;

⁴ орон нутгийн хөгжлийн бодлоготой нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт № 3-аар үзүүлэв

А.2. Орон нутгийн саналд үндэслээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтыг 2022 оны Төсвийн тухай хуулиар баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁵-т заасны дагуу төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх ажлын хэсэг байгуулагдаж холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэн, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой, үр дүнтэй эсэхийг тогтоож ажилласан байна.

Ажлын дүнд Засаг дарга төлөвлөлтийн эрэмбэд орж үнэлэгдсэн 91 ТАХ-ний саналыг 11 салбар яамдын сайдуудад хүргүүлсэн боловч 18 ТАХ буюу 19.7 хувь нь 2022 оны Төсвийн хуулиар батлагдсан байна. Аймгийн Засаг даргын төсөвлөлтийн шаардлага хангуулж хүргүүлсэн хөрөнгө оруулалтын саналын дийлэнх хувийг батлаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулах эрсдэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶-т зааснаар хөрөнгө оруулалт нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх шаардлагатай.

Эрх шилжин шинээр хэрэгжсэн 11 ТАХ нь холбогдох зөвшөөрөлгүй, техникийн эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй хуулиар батлагдсан байна. Энэ нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал,

- Аялал жуулчлал, байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг барих ажлын хэрэгжих байршилд газрын зөвшөөрөл олгогдоогүй тул шалгарсан гүйцэтгэгч ажил гүйцэтгэхээс татгалзаж, гэрээг цуцалсан байна.
- Тоног төхөөрөмж худалдан авах 10 ТАХ-ний техникийн тодорхойлолт, төсөвт өртгийг салбар яам нь тогтоогоогүйгээс зарим ажил хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна. **Жишээ нь:** “Шинэ хөдөө” төслийн Багц 1, 2, 3-ын төсөвт өртгийг аймгийн ЗД-ын захирамжаар нэмэгдүүлэн баталснаас “Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах” 5 дахь багцын ажил хэрэгжих боломжгүй болсон.
- Шаардлагад нийцсэн үзүүлэлт бүхий тоног, төхөөрөмж авахгүй байх эрсдэл үүссэн. Жишээ нь:
 - Жижиг, дунд оврын усалгааны систем төсөл, арга хэмжээний “1.5-25 км хол зайд, 20 метр өндөр хүртэл ус шахах, цахилгаан зарцуулахгүй, усны урсцаар ажиллах” гэсэн бодит байдалд нийцэхгүй үзүүлэлт бүхий техникийн тодорхойлолт боловсруулсан;
 - Бизнес хөгжлийн төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний тодорхойлолт дээр компьютерыг i3-аас i5, зөврийн компьютер i5-аас i7, зурагт 40-өөс-42 инч гэж техник үзүүлэлтийн ялгаатай, худалдан авах үнэ ижил техникийн тодорхойлолт боловсруулсан.

УТХО-аар хийгдэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийн шатанд төслийн санал боловсруулахдаа холбогдох мэдээллийг цахим системд оруулснаар урсгал зардал, орон тоо, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоолон бодож гаргах боломжтой байхад 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн дээрх тооцооллыг төлөвлөлтийн шатанд гүйцэтгээгүй байна.

⁵ "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7⁷-д зааснаар хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд эрэмбэлэх журмыг баримтлах ёстой.

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн 44 хувь, тоног, төхөөрөмж худалдан авах хөрөнгө оруулалтын 70 хувь хөдөө, аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн хөрөнгө оруулалт болсон байна.

Орон нутгийн саналд үндэслээгүй, төсөвлөлтийн шаардлага хангуулж урсгал зардлыг тооцоогүй төсөл, арга хэмжээнүүдийг баталсан байна.

БҮЛЭГ Б:

УТХО-ААР ХЭРЭГЖСЭН 3,007.8 САЯ ТӨГРӨГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АШИГЛАЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. УТХО-аар хэрэгжсэн 2,509.5 сая төгрөгийн 6 арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан бөгөөд Засгийн газар нь 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоолоор ТАХ-г хэрэгжүүлэх боломжтой хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна. Нийт ТАХ-ний ХАА-г эхний 4 сард багтаан зарласан байна.

ХАА-ны тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 145 дугаар тушаал /ажил гүйцэтгэх/, 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 124 дүгээр тушаал /харьцуулалтын аргаар бараа худалдан авах/ 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 144 дүгээр тушаалаар /бараа худалдан авах/ баталсан жишиг тендерийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, баталж ажилласан байна.

ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлан худалдан авах ажиллагааны журмыг хуулийн дагуу сонгон, нийт ХАА-г цахим системээр зарлаж ил тод байдлыг хангасан байна.

ХАА-ны хуульд нийцээгүй дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

1. ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан 230.0 сая төгрөгийн 2 ХАА-г тодорхой шалтгаангүйгээр зарлаагүй.
2. Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөн ХАА-г 2-3 удаа зохион байгуулж амжилтгүй болсны дараа харьцуулалт, шууд гэрээ байгуулах аргыг сонгосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчиж байна. Худалдан авах ажиллагааны журам өөрчилсөн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	НТШ зарласан тоо	Бууруулсан журам
1	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Эрдэнэбулган, Тосонцэнгэл, Рашаант, Галт, Бүрэнтогтох, Арбулаг, Их-Уул, Цагаан-Уул, Төмөрбулаг, Түнэл сум/	200.0	3	Харьцуулалт /1удаа/
2	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/ арга хэмжээг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох багц-2 Газар тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмжийн иж бүрдэл	200.0	2	Шууд гэрээ байгуулах /1/

⁷ 13.1.7. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална: 13.1.7.хөдөө аж ахуй, хүнс, импортыг орлох хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд эрэмбэлэх.”

3	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Хөвсгөл/ төсөл арга хэмжээ багц-1 Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн тугалтай үнээ, шүдлэн гунж худалдан авах	315.0	3	Харьцуулалт /3 удаа/
4	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Хөвсгөл/ төсөл арга хэмжээ багц-2 Махны чиглэлийн герефорт үүлдрийн үржлийн шүдлэн бух худалдан авах	56.0	3	Харьцуулалт /3 удаа/
5	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Хөвсгөл/ төсөл арга хэмжээ багц-3 Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн бухан бяруу худалдан авах	128.5	3	Харьцуулалт /3 удаа/
6	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/ багц-8 Газар хадлангийн нөөц бүрдүүлэх, ногоон тэжээл тариалах иж бүрдэл, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл худалдан авах	1,610.0	3	Харьцуулалт /3 удаа/
Нийт		2,509.5		

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4⁸ дахь заалтыг зөрчиж байна.

УТХО-аар хэрэгжсэн 2,509.5 сая төгрөгийн 6 арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй нь холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Б.2. Төсөл, арга хэмжээнүүдийг зураг, төсөл, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж хүлээж авсан байна.

Тайлант онд хэрэгжих барилга, байгууламжийн 17 төсөл, арга хэмжээний 16 шилжих, шинэ 1 барилга байгууламжийн ажил байна. Үүнээс 8 төсөл, арга хэмжээ нь өмнөх онд хэрэгжиж дууссан үлдэгдэл санхүүжилтээ авч байгаа бол тайлант онд 4,130.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 4 ТАХ хэрэгжиж дууссан байна. Үүнд:

1. Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Түнэл сум/,
2. Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/
3. Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Хөвсгөл, Мөрөн сум/
4. Нийтийн ариун цэврийн байгууламжийн дуусгал /Хөвсгөл, Мөрөн сум/

Дараа онд шилжин хэрэгжих 6 ТАХ нь гэрээний хугацаа сунган ажлыг гүйцэтгэж, 1 ТАХ-ний гэрээ цуцлагдаж, хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга, байгууламжийн ажлуудыг батлагдсан зураг, төслийн дагуу гүйцэтгүүлж, гэрээний хугацааг хууль, журмын дагуу сунгаж ажилласан байна.

Тайлант онд их засварын ажил хийгдээгүй байна.

Тоног, төхөөрөмж худалдан авах 7,031.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

Тоног төхөөрөмж худалдан авах 5,202.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 багц арга хэмжээний 4,516.6 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийг захиалагч хүлээн авсан байна.

Аудитаар тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын үзүүлэлттэй тулган хянахад техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцсэн байна.

⁸ 30.4. Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;

30.4.2.энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;

30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах.

Захиалагч нь тоног, төхөөрөмж нийлүүлэх ажлын гэрээний биелэлтийг хангуулах, шийдвэрлэх арга хэмжээ аваагүй дараах зөрчлүүд гарч байна. **Үүнд:**

1. Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн 107.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүнсний зориулалттай модон сав/ багц-1/, Сэрээт өргөгч/ багц-2/ нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Төрөлх Мөрөн” ХХК-ний гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллаагүй.
2. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн багц-1 ажлын 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Багийн засаг дарга, багийн эмч нарт тоног төхөөрөмж” ТАХ-ний санхүүжих дүн багассан гэх шалтгаанаар гэрээ байгуулсан “Кибер жаал” ХХК нь тоног төхөөрөмжөө бүрэн нийлүүлэхгүй байхад шаардлага тавьж ажиллаагүй.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” 2.1.2.6⁹-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

УТХО-аар 2022 онд зураг төсөл боловсруулах 300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг, төсвийг аймгийн ОНӨГ хүлээж авсан байна.

Өмнөх жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр ажил нь эхлээд одоог хүртэл дуусаагүй дараах барилга байгууламжууд байна. /Зургийг хавсралт №9-р харуулав./ Үүнд:

Хүснэгт № 5

№	Төсөл, арга хэмжээ	Эрх шилжсэн эсэх	Төсөвт өртөг /сая.төгрөг/	Хэрэгжиж эхэлсэн огноо	Гүйцэт гэл	Улсын комисс хүлээн авсан эсэх	Тайлбар
1	Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажил	Үгүй	4717.0	2013	90 %	-	Улсын комисс хүлээн авсан гэх баримтгүй.
2	Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажил	Тийм	3,500.0	2018	80 %	2020.12.22-ны өдрийн УҚД-2020/95	Сумын ЗДТГ-с Авлигатай тэмцэх газарт хандсан.
3	Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил	Үгүй	1,230.0	2019	20 %	Үгүй	Ажил хийгдэхгүй байгаа талаар холбогдох байгууллагад санал хүргүүлсэн.
Нийт			9,447.0				

Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлын тухайд 2012 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртгийг анх 1,800.0 сая төгрөгөөр баталж, 2013 онд 3,280.0 сая төгрөг болгож, 2020 онд 4,717.0 сая төгрөг болгож нийт 2,917.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажил, Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын тухайд төсөвт өртгийг нэмэгдүүлээгүй байна.


Захиалагч, ХБТХОХ нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс зарим төсөл, арга хэмжээний санхүүжилт татагдаж орон нутаг дахь хөрөнгө оруулалтын үр дүн буурсан байна.

⁹ төслийн хэрэгжилтийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих;

Б.3. Барьцаа хөрөнгөнөөс 88.8 сая төгрөгийн санхүүжилтийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр гүйцэтгэгчээс өөр хуулийн этгээдэд олгосон байна.

Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар эрх шилжин хэрэгжсэн 31 ТАХ-ний гүйцэтгэлд 13,213.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан бөгөөд үүнээс 29 ТАХ-ний гүйцэтгэлд 12,439.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдож санхүүжилтийн гүйцэтгэл 94 хувьтай байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



УТХО-ын санхүүжилтэй холбоотой дараах зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн Багц-1 Багийн засаг дарга, багийн эмч нарт тоног төхөөрөмж ТАХ-ний гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-3.9¹⁰-д тоног төхөөрөмжийг 100 хувь нийлүүлсэн үед санхүүжилтийг олгохоор заасан байна. Гэтэл гүйцэтгэл 69.8 хувьтай байхад 243.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.
2. УТХО-аар хэрэгжсэн “Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл” ТАХ-ний барьцаа 88.8 сая төгрөгийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Хөвсгөл Ус суваг ХХК, Төрөлх мөрөн ХХК хоорондын гэрээг үндэслэн захиалагчийн шийдвэргүй Хөвсгөл Ус суваг ХХК-д олгосон. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2.8¹¹ дахь заалтад нийцээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжин хэрэгжсэн 2 ТАХ-д нэмэлт санхүүжилтийн гэрээ, 4 ТАХ-д дуусгалын ажлын гэрээ байгуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн гэрээг холбогдох дээд шатны байгууллагуудын шийдвэрийг үндэслэн байгуулсан байна. /Гэрээ байгуулсан үндэслэл тайлбарыг хавсралт №4-өөр харуулав/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний заалтыг харгалзахгүйгээр олгосон, барьцаа хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөр хуулийн этгээдэд олгосон нь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтсийн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.

Б.4. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь барилгын ажлын явцад хяналт хийхгүй байгаа нь барилгын ажлын чанарт сөрөг нөлөө учруулах эрсдэлтэй байна.

¹⁰ Төлбөр төлөх хугацаа: Барааг бүрэн нийлүүлж дууссаны дараа санхүүжилтийг олгоно. Эцсийн хугацаа 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр болно.

¹¹ Орон нутагт хийгдэж байгаа төсвийн хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой асуудлаар иргэд гомдол гаргавал нутгийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, боломжгүй бол асуудлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, хяналт шалгалтын мэргэжлийн байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹², 2.8¹³-д заасны дагуу аймгийн Засаг дарга “Барилга захиалагчийн хяналтын төв”-тэй гэрээ байгуулан захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, заавар, зөвлөмжийг өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.

Аймгийн ГХБХБГ-аас барилгын ажлын явцад хяналт хийж ажиллаагүй байна. Энэ нь Барилга захиалагчийн хяналтын төв захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаатай холбоотой боловч дээрх үндэслэлээр барилгын асуудал эрхэлсэн төрийн байгууллага явцын хяналт хэрэгжүүлэхгүй байх нь барилгын ажлын чанарт сөрөг нөлөө учруулах эрсдэлтэй байна.

Аймгийн ТЕЗ-ын дотоод хяналтын нэгж болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний биелэлтэд хяналт хийхээр төлөвлөөгүй бөгөөд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь барилгын ажлын явцад хяналт хийж ажиллаагүй байгаа нь барилгын ажлын чанарт сөрөг нөлөө учруулах эрсдэлтэй байна.

Б.5. УТХО-аар хэрэгжсэн 3,007.8 сая төгрөгийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

Тайлант онд 31 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд багц болгон задалсан дүнгээр нийт 61 арга хэмжээ хэрэгжиж, үүнээс 34 арга хэмжээний ажил, тоног төхөөрөмжийг 2022 онд ашиглалтад хүлээн авсан байна. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний 4 нь барилга, байгууламжийн ажил байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь төсөл, арга хэмжээний нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авахдаа тухайн тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасан марк, хүчин чадал үзүүлэлттэй тохирч байгаа эсэх, заасан тоо хэмжээ бүрдэл нь бүрэн эсэхийг үзэж ажлын хэсгийн нийт гишүүдийн саналыг авч акт үйлдэн хүлээн авсан байна. Тус актад гэрээний биелэлтийг бүрэн биелүүлсэн эсэхэд дүгнэлт өгч дутуу /зөөврийн компьютерын дагалдах хэрэгсэл цүнх/ зүйлийг хүлээн авах ажлын хэсгийн гишүүний санал тусгах хэсэгт тусган хэрэгжүүлсэн байна.

Барилга байгууламжийн тухайд: Барилгын тухай хууль, Засгийн газрын 2021 оны 212 дугаар “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм” тогтоолд заасны дагуу зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт, захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг гаргаж ажилласан байна.

Хэрэгжиж дууссан ТАХ-г хууль, дүрмийн дагуу дүгнэлт гарган хүлээн авсан байна.

ТАХ-ний сүүлийн санхүүжилтийг олгоход гэрээ байгуулсан ажлын хэсэг гэрээг дүгнэж, үүргийн биелэлтийг тооцсон байна. Хугацаандаа хэрэгжээгүй 1 ТАХ-нд гэрээний дагуу алданги тооцон санхүүжилтээс 2.3 сая төгрөгийг суутган авсан байна.

Гэрээнд заасан хугацаанд 22 гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэсэн бол 9 гүйцэтгэгч тухайн цар тахал /ковид/, хил гааль хаалттай байгаагаас шалтгаалан гэрээнд заасан үүргээ

¹² Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹³ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.(Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмсэн)

биелүүлэх боломжгүй болсон талаар захиалагчид санал ирүүлж, гэрээний хугацааг сунгасан байна.

УТХО-аар 2022 онд бий болсон 5,106.8 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар холбогдох байгууллагууд бүртгэсэн байна.

Өмч бүртгэхтэй холбоотой дараах зөрчил дутагдал гарч байна. **Үүнд:**

1. Төрийн үйлчилгээний тоног төхөөрөмж - Сумдын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн засаг дарга нарт зөөврийн компьютер арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн Asus-X515-i3 зөөврийн компьютерыг тушаал гаргахдаа Dell inspiron 3155 гэж тухайн тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг зөрүүтэй бичсэнээс үүдэн зөөврийн компьютер хүлээн авсан газрууд 111.4 сая төгрөгийн 79 ш тоног төхөөрөмжийг өөр, өөр нэршлээр хөрөнгөд бүртгэсэн байна.
2. Хөрөнгийг бодитоор хүлээж аваагүй боловч ҮХ маягыг хөтлөн бүртгэлд тусгасан дараах тоног төхөөрөмжүүд байна. **Үүнд:**
 - Боловсролын салбарын тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний Багц-1 Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн албан хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээний ерөнхий боловсролын сургуульд нийлүүлсэн 3.5 сая төгрөгийн 3 тоног төхөөрөмж, хүүхдийн цэцэрлэгт 4.8 сая төгрөгийн 4 тоног төхөөрөмж нийт 8.3 сая төгрөгийн 7 тоног төхөөрөмж,
 - "Шинэ хөдөө" төсөл, арга хэмжээний багц-7 Ашиглалтын зардал багатай эрчим хүч, шатахуун зарцуулдаггүй эдийн засгийн хэмнэлттэй, инновацын шийдэлтэй, голоос тариалангийн талбай руу ус шахах услалтын систем нийлүүлэх ажлын 29.5 сая төгрөгийн 2 тоног төхөөрөмж/барша помп/
3. Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын ажлын зураг, төсвийг 300.0 сая төгрөгөөр хийлгэж хүлээн авсан боловч хөрөнгөд бүртгээгүй байна.

Зам засварын ажлын 300.0 сая төгрөгийн зураг, төсвийг хөрөнгөд бүртгээгүй байна. Төсөл, арга хэмжээний ашиглалттай холбоотой дараах асуудал илэрч байна. Үүнд: Ашиглалтад бүрэн хүлээн авсан боловч одоог болтол зориулалтын дагуу ашиглаагүй, хэрхэн ашиглах нь тодорхойгүй нийт 3,007.8 сая төгрөгийн 1 барилга байгууламж, 12 төрлийн тоног төхөөрөмж байна. /Хавсралт №5 харуулав./

УТХО-аар хүлээн авсан 3,007.8 сая төгрөгийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

БҮЛЭГ В.:

ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨН, ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнүүд нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна. /Төсөл, арга хэмжээ бодлогын баримт бичгүүдийн нийцлийг хавсралт №6 -аар харуулав./

Богино хугацааны буюу бодлогын баримт, бичиг буюу Хөвсгөл аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй 357.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ төлөвлөн, баталсан байна. Үүнд:

Хүснэгт №5

№	Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	2.3	Уурын зуухны буулгалтын зардал/Титэм сургуулийн зүүн талын уурын зуухны барилга/	49.2
2	2.5	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0
3	2.6	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0
4	2.10	Гудамж талбайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт/Мөрөн сум/	30.0
5	2.15	Нийтийн зориулалттай орон сууцны узель, шугам сүлжээг шинэчлэх ажил/Мөрөн сум 8 дугаар баг, 18 дугаар байр/	68.4
6	2.16	Газар чөлөөлөх Г байрыг буулгах /Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/Мөрөн сум	19.8
Нийт			357.4

Дээрх зөрчил нь тухайн онд тавьсан зорилт, үр дүнд хөрөнгө оруулалтаа чиглүүлж ажиллаагүй байгааг харуулж байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁴, 6 дугаар зүйлийн 6.5.5¹⁵, 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹ дүгээр зүйлд зааснаар төсвийн холбогдох зөвшөөрлүүд олгогдсон, зураг, төсөвтэй, хэрэгцээ шаардлага, саналд үндэслэсэн, олон нийтийн санал авч, эрэмбэлэгдсэн, урсгал зардал тооцсон, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хяналт хийхэд дараах Төсвийн тухай хуульд нийцээгүй зөрчил илэрч байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 2,934.5 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын саналд үндэслээгүй байна.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, хэрэгжүүлэх дараалалд олон нийтийн санал аваагүй байна.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй 210.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Үүнд:

Хүснэгт №6

№	Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	2.5	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0
2	2.6	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0
3	2.8	Төв суурины орчимд хамгаалалтын зурвас байгуулах ажлын хүрээнд Мөрөн сумын зарим ногоон байгууламж нэмэгдүүлэх	20.0
Нийт			210.0

¹⁴ 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

¹⁵ хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

4. Зураг, төсөвгүй 892.9 сая төгрөгийн хүснэгтэд заасан 9 төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна. Үүнд:

			хүснэгт №7
№	Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	1.9	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	14.4
2	2.2	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин, тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах	49.4
3	2.2	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0
4	2.5	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0
5	2.6	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0
6	2.7	Мод тарьж, ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа, хайс барих, шинэчлэх /Мөрөн сум 5 дугаар баг/	500.0
7	2.10	Гудамж талбайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт	30.0
8	2.16	Газар чөлөөлөх Г байрыг буулгах /Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/Мөрөн сум/	19.8
9	2.20	Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх /Мөрөн сум/	39.3
Нийт			892.9

Зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлснээс үүдэн 2023 онд Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/, Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/ гэсэн 2 төсөл, арга хэмжээнд 90.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих 38 төсөл, арга хэмжээг 2,979.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. /төсөл, арга хэмжээний баталсан санхүүжилтийн хуваарийг хавсралт №2-оор үзүүлэв/ Санхүүжилт олгохоор баталсан төсвийн 2,293.2 сая төгрөг нь 3,803.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл, арга хэмжээний бүтэн санхүүжилт байна. Өндөр төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг дараа он руу хувааж баталсан байна. Төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай харьцуулбал хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталсан байна.

Дээрх зөрчлүүд нь 2022 оны хөрөнгө оруулалтын аудитаар гарч байсан бөгөөд энэ аудитаар давтагдан гарч байна. Өмнөх аудитаар аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ХБТХОХ-ийн дарга нарт зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжүүлээгүй байх тул зөрчил арилгах **албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд заасан хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангахгүй, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгаагдаагүй байна.

В.2. Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар барьцаа, магадалшгүй ажлын 12.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн хөрөнгө төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих 26, өмнөх оноос шилжиж ирсэн 1 нийт 2,318.7 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тайлант онд зохион байгуулсан байна. Дээрх худалдан авах ажиллагаануудаас харьяалах шатны байгууллагуудад 94.5 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнд 2,152.8 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгаруулж 2,089.7 сая төгрөгийн гэрээ байгуулан 63.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан.

Тендерт оролцогчгүйн улмаас 165.9 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй байна.

Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэн хуульд нийцүүлэн тендер шалгаруулалтын журам, зарлах хэлбэрийг сонгон хэрэгжүүлсэн байна.

Аудитын хүрээнд төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, баримт, тендерийн баримт бичигт хяналт хийхэд дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

1. Аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах технологийн шийдэл/Хөвсгөл ус суваг ХХК/ төсөл, арга хэмжээ нь аймгийн 2022 оны Төсвийн тодотголоор 28.9 сая төгрөгөөр батлагдсан. Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Хөвсгөл ус суваг ХХК хүлээн авах байтал аймгийн Засаг даргын 2022 оны А/241 дүгээр захирамжаар “Хөвсгөл Ус суваг”ХХК-д ХАА-ны эрхийг шилжүүлсэн байна. Энэ нь НАНБХАСЗУСТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2.4¹⁶ дахь заалтад нийцээгүй байна.
2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй байна. Тухайлбал:
 - Баяр наадмын талбайн засварын “Үзэгчдийн шаталсан суудал солих, засварлах ” /Мөрөн сум/,
 - Аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах технологийн шийдэл /Хөвсгөл ус суваг ХХК/ Энэ нь НАНБХАСЗУСТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1¹⁷, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2.9¹⁸ заалтыг зөрчсөн байна.
3. Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг 165.5 сая төгрөгийн 4 мэдээллээр зөрүүтэй гаргасан байна. /зөрчлийг хавсралт №7-оор үзүүлэв./ Энэ нь Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.2¹⁹, 4.5²⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна. Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжилт олгосон 38 төсөл, арга хэмжээний 1,471.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ нь өмнөх онуудад хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ байсан бол тайлант онд 3,239.6 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан байна.

Энэ дүнгээр авч үзвэл 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 70.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

¹⁶ 7.2.4. Төрийн байгууллагын удирдлага ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй: ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх;

¹⁷ 8.1. Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

¹⁸ 49.2.9 тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг;

¹⁹ 4.2. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын маягт 2-ын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

²⁰ “Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана.”

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Орон төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд батлагдсан 38 төсөл, арга хэмжээнд 2,979.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна. Батлагдсан санхүүжилтээс 33 төсөл, арга хэмжээнд 2,377.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /санхүүжилтийн гүйцэтгэлийг хавсралт №8-аар үзүүлэв/ Санхүүжилтийг олгохдоо дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

1. Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/ төсөл, арга хэмжээний сүүлийн санхүүжилтээс 5.0 сая төгрөгийн барьцаа суутгаагүй, 1.6 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг магадалшгүй ажлын актгүй урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон.
2. Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/ төсөл, арга хэмжээний сүүлийн санхүүжилтээс 4.5 сая төгрөгийн барьцаа суутгаагүй, 1.6 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг магадалшгүй актгүй урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон.
3. Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх төсөл, арга хэмжээний сүүлийн санхүүжилтээс 2.0 сая төгрөгийн барьцаа суутгаагүй, 0.5 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг магадалшгүй актгүй урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон. /Аудитын явцад буцаан төвлөрүүлэв/

Эдгээр зөрчлүүд нь ажил гүйцэтгэх гэрээний 2 дугаар хавсралт гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-5.2²¹ дахь заалтыг зөрчиж байна. Гэрээ зөрчиж олгосон санхүүжилтийг орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд буцаан төвлөрүүлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв. Бусад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон байна.

Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар барьцаа, магадалшгүй ажлын 12.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хөрөнгө оруулалтын барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлд Барилга, захиалагчийн хяналтын төв, бусад төсөл, арга хэмжээний хувьд тухайн ажлыг хүлээж авахаар байгуулагдсан ажлын хэсэг хяналт хэрэгжүүлж ажилласан байна. Ажил хүлээн авах ажлын хэсэг нь хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлсэн байна.

Харин хөрөнгө оруулалтын барилга, байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлтэй тулган хянахад дараах төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд хяналтыг сул хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Мөрөн сумын орон сууцны 15 дугаар байрны дээврийн их засвар,
2. Мөрөн сумын орон сууцны 16 дугаар байрны дээврийн их засвар,
3. Мөрөн сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх төсөл, арга хэмжээнүүд нь гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй төлөвлөсөн үр дүнд хүрээгүй,
4. Хатгал тосгоны цэцэрлэгийн гал тогооны засвар төсөл, арга хэмжээгээр цэцэрлэгийн галт тогоонд уур сорогч суулгасан боловч уур сорогч нь ажиллахгүй, чийг цан их хэмжээгээр үүсгэн, хийгдсэн засварын чанар, үр дүнг багасгаж байна.

²¹ ГЕН-5.2 "Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна"

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд Барилга захиалагчийн хяналтын төв хяналт тавьж ажилласан бөгөөд ажлыг цаг хугацаанд гүйцэтгүүлэх талаар шаардлага тавиагүй, дууссан төсөл, арга хэмжээнд хийх хяналт хангалтгүй байна.

Төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан, ажлыг хүлээн авсан боловч баталгаат хугацаанд гарсан алдаа, доголдлыг арилгуулж ажиллах шаардлагатай байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийх чиг үүрэг бүхий аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь 2022 онд хөрөнгө оруулалтад хийх хяналтыг төлөвлөөгүй, хяналт хийж ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.1.3²², Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.11²³ дахь заалтуудад нийцэхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдээс 3,389.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээг 2022 онд хүлээн авч, ашиглалтад оруулсан байна. Үүнээс 3,155.2 сая төгрөгийн 19 төсөл, арга хэмжээний барилга, байгууламж, засварын ажлыг улсын комисс ажиллан хүлээн авсан байна. Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Тайлант онд ОНТХО-аар өмчлөл үүсгэсэн 398.8 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээний 11 нэгж хөрөнгийг холбогдох байгууллагууд хөрөнгөд бүртгэн хүлээн авсан байна.

ОНТХО-ын 3,389.6 сая төгрөгийн 24 төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлыг хууль журмын дагуу хүлээж авсан байна.

²² Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ: төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;

²³ Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь байгууллагын ил тод байдлын үнэлгээг энэ журмын 9 дүгээр хавсралтын дагуу гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мөн журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд хүргүүлнэ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл арга хэмжээг төлөвлөхдөө улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны Хөгжлийн бодлогуудад нийцүүлээгүй, орон нутгийн саналд үндэслээгүй, төсөвлөлтийн шаардлага хангуулж батлаагүй байна.
2. УТХО-аар хэрэгжсэн 2,509.5 сая төгрөгийн 6 худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй нь холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүйг харуулж байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд нь хугацаандаа хэрэгжиж, үр дүнгээ өгөхгүй байгаа нь барилгын материалын үнэ нэмэгдсэн, цар тахлын хүрээнд хил гааль хаагдсан, анх батлагдсан төсвөөр хэрэгжүүлэх боломжгүй болсон шалтгаанаар нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг гэрээний заалтыг харгалзахгүйгээр олгосон, барьцаа хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, гүйцэтгэгчээс өөр хуулийн этгээдэд шилжүүлсэн, урьдчилгаа төлбөрийн баталгаагаар барьцаа, магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэгчид олгосон нь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтсийн хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.
5. Өмнөх онуудад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээ өдийн болтол дуусаагүй, тайлант онд хэрэгжсэн зарим барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.
6. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь барилгын ажлын явцад хяналт хийж ажиллаагүй байгаа нь барилгын ажлын чанарт сөрөг нөлөө учруулах эрсдэлтэй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитаар дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуягт:

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, саналд үндэслэсэн, нийцсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг батлах

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд:

1. Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, саналд үндэслэсэн, ач холбогдолтой, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөх
2. Төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлэхдээ санхүүжилт авах байгууллагад нь эрх шилжүүлэхгүй байх
3. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хүлээн авсан боловч одоо болтол зориулалтын дагуу хэрхэн ашиглах нь тодорхойгүй, холбогдох байгууллагын бүртгэлд байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлийг нарийвчлан тогтоож, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөн-Эрдэнэд:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгох, хянах албан хаагчдад хяналт, хариуцлагыг сайжруулах.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяад:

1. Төсөвт байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад төлөвлөхгүй байх
2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авах.

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсоргодогт:

1. Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заагдсаны дагуу зохион байгуулж ажиллах, хяналтыг сайжруулах
2. Худалдан авах ажиллагааны журмыг бууруулан хэрэглэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4 дахь заалтыг баримталж ажиллах
3. Техникийн нэр зөрүүтэй гаргасан тушаал болон холбогдох байгууллагуудад бүртгэсэн хөрөнгийн нэршлийг өөрчилж алдааг залруулан, эд хөрөнгийг хүлээн авагч байгууллага бодитоор хүлээн авсан үед үндсэн хөрөнгөд бүртгүүлж байх

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Ганзоригт:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй нийт барилгын ажилд явцын хяналт хийж ажиллах

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн дарга Д.Батчулуунд:

1. Хяналт хийж буй төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд чанартай хэрэгжүүлж ажиллах талаар шаардлага тавьж, хариуцлага тооцож ажиллах
2. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнд барилгын баталгаат хугацаанд хяналт хэрэгжүүлж алдаа, зөрчлийг арилгуулж ажиллах

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Г.Мөнхтулгад:

1. Төсвийн хөрөнгө оруулалтад аудит хийж, үр дүнг сайжруулж ажиллах

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Янжиндолгорт:

1. Төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийж үнэлгээ өгч ажиллах

Зөрчлийн жагсаалт:

/сая төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	УТХО-ын 315.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцээгүй.	315.0						
2	УТХО-ын 2,714.5 сая төгрөгийн 18 арга хэмжээ Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй.	2,714.5						
3	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 3,485.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний 14 багц арга хэмжээ нийцээгүй.	3.485.5						
4	Орон нутгийн саналд үндэслээгүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлснээс үүдэн Хөдөөгийн шийдэл ОНӨААТҮГ байгуулсан орон нутгийн төсөвт сөрөг нөлөөтэй байна.	-						
5	Ерөнхий нэршилтэй, хийгдэх ажил нь тодорхой бус, ажлын даалгавар, зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээнүүдийг эрх шилжүүлсэн.	-						
6	Аймгийн Засаг даргаас баталсан төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтуудад тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үзүүлэлтийг ерөнхий байдлаар тооцож, хүчин чадлыг хэлбэлзэлтэй юм уу хэт өндөр тавьж өгсөн	-					1	-
7	Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдан 2022 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцоогүй.	-					1	-
8	Тодорхой шалтгаангүйгээр 1.Талх нарийн боовны тоног төхөөрөмж, 2.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах гэсэн 230.0 сая төгрөгийн 2 арга хэмжээнд худалдан авах ажиллагаа явуулаагүй байна.	230.0					1	230.0
9	НТШ-ны ХАА-ны журмыг бууруулах хуулийн зохицуулалтыг буруу хэрэглэсэн	2,509.5					1	2,509.5
10	Багийн Засаг дарга, багийн эмч нарт тоног төхөөрөмж арга хэмжээний гэрээний заалтыг мөрдөж ажиллаагүй, гэрээний ГЕН-3.9 дэх заалтыг зөрчсөн	243.5					1	243.5

11	УТХО-аар хэрэгжсэн “Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл” /Хөвсгөл, Мөрөн сум/-ийг хэрэгжүүлэхээр 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан БХБЯ/2020011016/1.4.1-А/01 дугаартай гэрээнд заасны дагуу гүйцэтгэгчид олгох гүйцэтгэлийн баталгаа болох барьцаа хөрөнгийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Хөвсгөл Ус суваг ХХК гүйцэтгэгч Төрөлх мөрөн ХХК-тай байгуулсан гүйцэтгэгчийн үүргийг шилжүүлэн авах агуулгатай гэрээг үндэслэн байгуулан барьцаа 88.8 сая төгрөгийг Хөвсгөл Ус суваг ХХК-д шилжүүлсэн	88.8				1	88.8		
12	Хөрөнгийн оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэхдээ нэршил зөрүүтэй тушаал гаргасан, зарим эд хөрөнгийг бодитоор хүлээлгэн өгөөгүй байж өмчид бүртгэх тушаал гаргаж өмчид бүртгүүлсэн	142.2						1 142.2	
13	Ашиглалтын байдал тодорхойгүй 3,007.8 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн талаар тодорхой чиглэл гаргаагүй.	3,007.8						1 3,007.8	
	Дүн	9,736.8				1	88.8	7 6,133.0	
Орон нутгийн хөрөнгө оруулалт									
14	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар богино хугацааны буюу бодлогын баримт, бичиг буюу Хөвсгөл аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй 357.4 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ төлөвлөн, баталсан.	357.4						1 357.4	
15	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 2,934.5 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын саналд үндэслээгүй байна	-						1	
16	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, хэрэгжүүлэх дараалалд олон нийтийн санал аваагүй	-						1	
17	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжгүй 210.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлсэн	210.4						1 210.4	
18	Зураг, төсөвгүй 892.9 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ төлөвлөж, баталсан	892.9						1 892.9	
19	Санхүүжилт авах байгууллагад нь ХАА-ны эрх шилжүүлсэн	28.9						1 28.9	
20	ОНТХО-ын 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй байна.	-						1 -	
21	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг 165.5 сая төгрөгийн 4 мэдээллээр зөрүүтэй гаргасан байна.	165.5				1	165.5		

22	ОНТХО-ын 2 төсөл, арга хэмжээний гэрээний заалтыг зөрчиж урьдчилгаа төлбөрийн баталгаагаар барьцаа, магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэгчид олгосон	12.7			1	12.7		
23	Барилга захиалагчийн хяналтын төв нь ажлыг цаг хугацаанд гүйцэтгүүлэх талаар шаардлага тавиагүй, хэрэгжиж дууссан ТАХ-д хийх хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн	-					1	-
24	Төсвийн хөрөнгө оруулалтад хяналт хийх чиг үүрэг бүхий аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь 2022 онд хөрөнгө оруулалтад хийх хяналтыг төлөвлөөгүй, хяналт хийж ажиллаагүй байна.	-					1	-
	Дүн	1,667.8			2	178.2	9	1,489.6
	НИЙТ ДҮН	11,404.6	-	-	3	267.0	16	7,622.6

Байгууллагын саналууд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА

Нутгийн удирдлагын ордон, 3 дэвхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.
Утас: (976) 7038 3330.
Цахим шуудан: aimginithural@khs.gov.mn
Цахим хуудас: Khovsgol.Khural.mn

2023.04.20 № 02/481
танай 2023.04.19-ны № 01/333 -Т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Саналгүй.

Төрийн аудитын газраас ирүүлсэн “Улс орон нутгийн төсвийн 2022 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төслийг дэмжиж байна.

ДАРГЫН АЛБАН ГҮЙЦЭТГЭГЧ  ОРЛОН
Н.ТӨМӨРХУЯГ



Албан Бичиг A5docxUser

671000034

2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар



МОНГОЛ УЛС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001

Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn

Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2023.04.21 № 2/69
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Саналгүй.

“Улс орон нутгийн төсвийн 2022 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах саналгүй байна, зөвлөмжийн хэрэгжилтийн ханган ажиллана.

ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР



67120304



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsguizdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2023. 04. 21 № 3/690
Танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Саналгүй.


“Улс орон нутгийн төсвийн 2022 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтөй танилцлаа. Тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах саналгүй байна, зөвлөмжийн хэрэгжилтийн ханган ажиллана.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Б.МӨНГӨН-ЭРДЭНЭ



671 1030709

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс:



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7036 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2023.07.20, № 6/657.
танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр
дүн” гүйцэтгэлийн аудитийн тайлангийн төсөлтэй
танилцаж тайлбар саналаа хавсралтаар хүргүүлэв.

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНТУЯА**



6711090619

Санал гаргасан байгууллагын саналыг хүлээн авч албан шаардлагыг хэрэгжүүлэх хугацааг 2023.07.05-ны өдөр болгосон.

4. Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс.



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

2023.04.20 № 8/638
Тамгай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Саналгүй.

“Улс орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтөй танилцлаа.


Тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах саналгүй байна, зөвлөмжийн хэрэгжилтийн ханган ажиллана.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.БАЗАР



671209000

5. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар



Саналыг хүлээн авах боломжгүй байна.

6. Барилга захиалагчийн хяналтын төв:



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ХӨВСГӨЛ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ ААТҮГ

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 3353

2023.04.20 № 02/64
танай _____-ны № _____-т

Аудитын дүгнэлтийн төсөлд тайлбар
хүргүүлэх тухай

**Тайлангийн төсөлд ирүүлсэн
саналыг хүлээн авах
боломжгүй байна.**

Танай байгууллагаас Хөвсгөл аймагт 2022 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн аудит хийсэн дүгнэлтийн төсөлтэй танилцаад доорх тодруулгыг хүргүүлж байна.

1. Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 дугаар баг 15, 16 дугаар байрны дээвэр/ төслийн тухайд 2022 онд 5-6 удаа тендер шалгаруулалт болж, 2022 оны 11 дүгээр сард гүйцэтгэгчээр “Бунбах” ХХК шалгаран ажлаа гүйцэтгэсэн. Энэ хугацаанд

- Дээврийн ажлыг бүрэн дуусгахын тулд агааржуулалтын хоолойн тоосгон өрлегийг өндөрлөж, дээврийн төмрөөс илүү гаргаж өрөх ажилбарыг гүйцэтгэхэд гадна агаарын температур хасах хэмд хүрч, барилга угсралтын ажил гүйцэтгэх боломжгүй технологийн зогсолттой давхацсан.
- Тухайн төсөл, арга хэмжээний 2022 оны төсөвт суугдсан зардлыг эргэж татуулахгүйн тулд үлдэгдэл ажлын төсвөөр баталгаа байршуулан, санхүүжилт олгох шийдвэр гаргасан болно. Манай байгууллага нь барьцаа суутгах гэх мэтийн санхүүгийн үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд ийм эрхгүй болно.

2. “Эрдмийн далай” цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байрны засвар: Гүйцэтгэгч “Голден прогресс” ХХК нь материал татан авалтыг оройтуулсан, ажлын зохион байгуулалт муутай ажилласан ба манай зүгээс гэрээт ажлыг хугацаандаа гүйцэтгэх тухай албан тоотыг удаа дараа хүргүүлэн шаардаж байсан


боловч үүрэг даалгаврыг биелүүлээгүй болно. Оны эцэст мөн урьдчилгаа төлбөрийн баталгаа байршуулан санхүүжилт авсан.

3. Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгийн гал тогооны засварын ажлын тухайд ашиглагч нь агааржуулалтын доголдолтой байгааг манай байгууллагад тухайн үед мэдэгдээгүй ба аудитын хяналтын явцад мэдээлэл авч, манай инженерүүд ашиглалтад орсны нь дараа агааржуулалтыг хэрхэн ажиллуулах заавар өгсөн. Ашиглагч байгууллага нь агааржуулалтыг горимын дагуу ажиллуулж чадаагүй байсан.

4. Дээрх гэрээт хугацаандаа хэрэгжээгүй төслүүд дээр төндөр шалгаруулалт оройтож, улмаар гэрээ баталгаажих, ажил эхлэх зөвшөөрөл гарах явц удааширч байсан нь гэрээт хугацаанд хэрэгжихгүй байх гол шалтгаан болсон.

5. Манай байгууллага нь өөрийн санхүүгийн боломжит хэмжээгээр орон нутагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний барилга угсралтын явцад хүрч ажиллан заавар, зөвлөмж, албан шаардлага өгч, биелэлтийг хангуулан ажиллаж ирсэн ба төсвийн хөрөнгийн үр ашиг, барилга байгууламжийн угсралтын чанарыг сайжруулахад өөрсдийн мэдлэг, дадлага, чадварыг дайчлан ажиллаж ирсэн болно.

Иймд гүйцэтгэлийн аудитын тайланд манай байгууллагын үйл ажиллагааг хууль, эрх зүйн хувьд зөв ойлгон, дэмжиж ажиллахыг уламжилж байна





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 сарын 20 өдөр

№ 67/АХХЗД/137/ХӨА-2023/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн УҚД-2020/84 дугаартай комиссын дүгнэлтээр хүлээн авсан “Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж” барилга байгууламжийн барьцаа хөрөнгийг “Хөвсгөл Ус суваг” ХХК нь гүйцэтгэгч “Төрөлх Мөрөн” ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр гэрээ байгуулсан гэрээг үндэслэн 88,826,245 (наян найман сая найман зуун хорин зургаан мянга хоёр зуун дөчин тав)-н төгрөгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр “Хөвсгөл Ус суваг” ХХК-д олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан БХБЯ/2020011016/1.4.1-А/01 дугаартай гэрээний 1.17 “Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөр төлөх болон чанарын баталгааны барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид чөлөөлөн олгох үүрэг хүлээнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Хөвсгөл Ус суваг” ХХК-д эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон барьцаа хөрөнгө 88,826,245 (наян найман сая найман зуун хорин зургаан мянга хоёр зуун дөчин тав)-н төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд буцаан төвлөрүүлж биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар нарт хариуцуулав.

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэхээр байгуулж буй гэрээг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Б.Мөнгөн-Эрдэнэд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР:

АУДИТОР:



А.ЭРДЭНЗБААТАР

З.ДАВААДОРЖ

Н.ГҮРБАЗАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 сарын 20 өдөр

№ 68/АБЭТ0138/ХӨА - 2023/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/ төсөл, арга хэмжээний сүүлийн санхүүжилтээс 4,999,248 (дөрвөн сая есөн зуун ерэн есөн мянга хоёр зуун дөчин найм) төгрөгийн барьцаа суутгаагүй, 1,611,130 (нэг сая зургаан зуун арван нэгэн мянга нэг зуун гуч) төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг ажлын актгүй урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон.
2. Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/ төсөл, арга хэмжээний сүүлийн санхүүжилтээс 4,499,928 (дөрвөн сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуун хорин найм) төгрөгийн барьцаа суутгаагүй, 1,562,747 (нэг сая таван зуун жаран хоёр мянга долоон зуун дөчин долоо) төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг ажлын актгүй урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон.

Энэ нь Ажил гүйцэтгэх гэрээний 2 дугаар хавсралт гэрээний тусгай нөхцөлийн ГЕН-5.2-т “Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сүүлийн санхүүжилтээс суутган тооцож 1 жилийн хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд байршуулна”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.17-д “Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон барьцаа, магадалшгүй ажлын зардал 12,673,053 (арван хоёр сая зургаан зуун далан гурван мянга тавин гурав) төгрөгийг төрийн сан дахь 100170051300 /Хө.Орон нутгийн хөрөнгө оруулалт/ дансанд буцаан дансанд төвлөрүүлж, зөрчлийг арилган, биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунтуяа, мэргэжилтэн Х.Буянтогтох нарт даалгав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АХЛАХ АУДИТОР:



А.ЭРДЭНЭБААТАР
З.ДАВААДОРЖ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 сарын 20 өдөр

№ 69/А2270438/ХӨА-2023/
28-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг 165,410,500 (нэг зуун жаран таван сая дөрвөн зуун арван мянга таван зуу) төгрөгийн 4 мэдээллээр зөрүүтэй гаргасан байна.

Энэ нь Энэ нь Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын маягт 2-ын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.” , 4.5-д ““Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1-т “Шалгаагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тайланг зөрүүтэй гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Должинсорогдог, Худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Болд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АХЛАХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР
В.ДАВААДОРЖ



Орон нутгийн төсвөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний жагсаалт

д/д	Төсвийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	1.1	АЗДТГ-ын барилгын байрны 3 давхрын засварын ажлын дуусгалт	55.2	10.0
2	Тодотгол 1.1	Спорт заалны барилга шинээр барих, барилга угсралтын ажлын дуусгалт /Эрдэнэбулган сум/	197.5	52.0
3	1.2 / тодотгол 1.2	Аймгийн "Авто зам"-ыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөрөн сумын хатуу хучилттай зам барих /Нэгдсэн эмнэлгийн урд уулзвараас ДЦС өнгөртөл -1.6 км/	850.0	399.5
4	1.3	Спорт заалны барилга /Шинэ-Идэр сум/	950.0	100.0
5	1.4	Аврах анги барих /Галт сум/	201.0	94.0
6	1.5	Багийн мэдээллийн төвийн барилга /Рашаант сум/	0.9	0.9
7	1.6	Баяр наадмын талбайн урд асрын засвар /Мөрөн сум/	229.4	209.4
8	1.7	Хөгжимт драмын театрын дээврийн засвар /Мөрөн сум/	100.0	30.0
9	1.8	Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар	50.0	9.5
10	1.9	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	14.4	14.4
11	1.10.	Гэрлэн чимэглэл хийх/Мөрөн сум/	79.3	19.6
12	1.11	Хоймор нутгийн чулуу ХХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн өмч төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, түүхий эдийн нөөц бүрдүүлэх, тогтоох, хайгуул хийх ажлын зөвлөх үйлчилгээ	40.0	2.0
13	Хуучин төсөв 2.1	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах тоног төхөөрөмжөөр хангах	90.0	90.0
14	2.1	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах /Мөрөн сум/	156.5	100.0
15	Хуучин төсөв 2.2	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин, тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах	49.4	49.4
16	Тодотгол 2.2	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0	40.0
17	2.3	Уурын зуухны буулгалтын зардал/Титэм сургуулийн зүүн талын уурын зуухны барилга/	49.2	49.2
18	2.4	Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга худалдан авах /Мөрөн сум 8-р баг/	119.4	119.4
19	2.5	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0	100.0
20	2.6	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0	90.0
21	2.7	Мод тарьж, ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа, хайс барих, шинэчлэх /Мөрөн сум 5,8 дугаар баг	500.0	300.0
22	2.8	Төв суурингийн орчимд хамгаалалтын зурвас байгуулах ажлын хүрээнд Мөрөн сумын зарим ногоон байгууламж нэмэгдүүлэх	20.0	20.0
23	2.9	Хатуу хучилттай авто замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах /Мөрөн сум төв зам/	20.0	20.0
24	2.10.	Гудамж талбайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт/Мөрөн сум/	30.0	30.0
25	2.11	Баяр наадмын талбайн засварын "Үзэгчдийн шаталсан суудал солих, засварлах"/Мөрөн сум/	40.0	40.0

26	2.12	Аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах технологийн шийдэл /Хөвсгөл ус суваг ХХК/	28.9	28.9
27	2.13	Хог хаягдлын эх үүсвэр дээр нь ангилан ялгалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хог пресслэх тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум/	70.0	70.0
28	2.14	Загас үржүүлгийн цөөрмийн загасны аж ахуй байгуулах ажлын хүрээнд Цагаан загас үржүүлэх аппарат худалдан авах /Цагааннуур сум/	20.0	20.0
29	2.15	Нийтийн зориулалттай орон сууцны узель, шугам сүлжээг шинэчлэх ажил/Мөрөн сум 8 дугаар баг, 18 дугаар байр/	68.4	68.4
30	2.16	Газар чөлөөлөх Г байрыг буулгах /Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/Мөрөн сум	19.8	19.8
31	2.17	Мөрөн сумын 14 дүгээр багийн ард камер тавих ажил /Нисэхийн аюулгүй байдлыг хангах/	5.5	5.5
32	2.18	Аймгийн НЭ-ийн амбулаторийн урд авто зам дагуу авто, зогсоол, явган хүний замын ажил /Мөрөн сум/	97.5	97.5
33	2.19	10 дугаар багт хашаа хайс, ногоон байгууламж нэмэгдүүлэх /Мөрөн сум/	35.0	35.0
34	2.20.	Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх /Мөрөн сум/	39.3	39.3
35	2.21	Морь барианы газарт нойл барих /Мөрөн сум/	20.0	20.0
36	2.22	Баяр наадмын талбайн гадна талбайн тохижилт, засвар /Мөрөн сум/	34.7	34.7
37	Хавсралт 5-ын 1	Аймгийн ЗДТГ-ын байрны их засвар	1,037.4	250.6
38	Хавсралт 5-ын 2	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн засварын ажил	300.0	300.0
Нийт			5,858.7	2,979.2

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй ТАХ-ний жагсаалт

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний задалсан нэр	Төсөвт өртөг
1	V.1.3.5	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл/	Багц-1 Багийн засаг дарга, багийн эмч нарт тоног төхөөрөмж худалдан авах	400.0
			Багц-2 багийн засаг дарга, багийн эмч нарыг унаажуулах /мотоцикл/ худалдан авах	70.0
			Багц-3 Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Мунгараг багт бэлчээрийн худаг гаргах ажил	30.0
2	V.1.3.7	Төрийн үйлчилгээний тоног төхөөрөмж /Хөвсгөл/	Багц-1 Багийн засаг дарга, багийн эмч нарыг унаажуулах /мотоцикл/ худалдан авах	173.0
			Багц-2 Сумдын Засаг даргын Тамгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн засаг дарга нарт зөөврийн компьютер худалдан авах	167.0
3	XII.1.116	Нийтийн ариун цэврийн байгууламжийн дуусгал /Хөвсгөл, Мөрөн сум/		140.0
4	XIII.1.3.11	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/	Багц-1 Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн албан хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авах	154.5
			Багц-2 “3х3 сагсан бөмбөгийн талбай” бараа худалдан авах	145.5
5	XV.1.4.6	Хэрээтийн даваа, Бийжийн даваа, Бор бургасын давааны зам засварын зураг төсөв /Хөвсгөл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/		300.0
6	XVII.1.25	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл, Эрдэнэбулган, Тосонцэнгэл, Рашаант, Галт, Бүрэнтогтох, Арбулаг, Их-Уул, Цагаан-Уул, Төмөрбулаг, Түнэл сум/		200.0
7	XVII.3.6	Бизнес хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Хөвсгөл, Мөрөн сум/		30.0
8	XVII.3.30	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/	Багц-1 махны чиглэлийн сэлэнгэ үүлдрийн тугалтай үнээ, шүдлэн гунж худалдан авах	315.0
			Багц-2 Махны чиглэлийн герефорт үүлдрийн үржлийн шүдлэн бух худалдан авах	56.0
			Багц-3 Махны чиглэлийн сэлэнгэ үүлдрийн бухан бяруу худалдан авах	128.5
			Багц-16 компьютер, принтер тоног төхөөрөмж худалдан авах	15.0
9	XIX.3.28	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Хөвсгөл/	Багц-1 Багийн эмч нарыг унаажуулах	128.0
			Багц-2 Нэгдсэн эмнэлэг, анхан шатны эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж	185.0
			Багц-3 Статистиктич эмч нарт шаардлагатай тоног төхөөрөмж	87.0
Нийт				2,724.5

Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичигт нийцээгүй ТАХ-ний жагсаалт

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний задалсан нэр	Төсөвт өртөг
1	XVII.3.10	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/		100.0
2	XVII.3.20	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Хөвсгөл/	Багц-1 хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж	100.0
			Багц-2 газар тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмжийн иж бүрдэл	200.0
			Багц-3 Талх нарийн боовны тоног төхөөрөмж	200.0
3	XVII.3.30	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл	Багц-6 Газар тариалангийн зориулалттай трактор, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл худалдан авах	380.0
			Багц-7 ашиглалтын зардал багатай эрчим хүч, шатахуун зарцуулдаггүй эдийн засгийн хэмнэлттэй, инновацын шийдэлтэй, голоос тариалангийн талбай руу ус шахах усалтын систем нийлүүлэх ажлын санхүүжилт	150.0
			Багц-8 газар хадлангийн нөөц бүрдүүлэх, ногоон тэжээл тариалах иж бүрдэл, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл худалдан авах	1,610.0
			Багц-9 арьс шир боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх	137.5
			Багц-10 дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж нийлүүлэх /8*4/ хэмжээтэй ажлын санхүүжилт	85.5
			Багц-11 Дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж нийлүүлэх /20*8/ хэмжээтэй ажлын санхүүжилт	322.5
			Багц-12 Талх нарийн боовны тоног төхөөрөмж худалдан авах гэрээ	83.0
			Багц-13 Цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах гэрээ	12.0
			Багц-14 Дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж нийлүүлэх /6*10/ хэмжээтэй гэрээ	45.0
			Багц-15 дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж нийлүүлэх /6*10/ хэмжээтэй гэрээ	60.0
			Нийт	

Нэмэлт санхүүжилт гэрээ, дуусгалын ажлын гэрээгээр санхүүжилт авсан ТАХ-ний жагсаалт

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Материалын үнийн зөрүү магадлагдсан дүн	Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан үндэслэл
Нэмэлт санхүүжилтийн гэрээгээр					
1	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн Мөрөн сум	2,293.0	1,999.0	294.0	УИХ-ын 2022 оны 88 дугаар "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" тогтоол, Сангийн сайдын 2022.12.16-ны өдрийн 01/8591 дугаартай албан бичиг, аймгийн Засаг даргын 2022.12.22-ны өдрийн А/461 дүгээр "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамж
2	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал Их-Уул сум	1,666.0	950.	716.0	
Нийт		3,959.0	2,949.0	1,010.0	
Дуусгалын ажлын гэрээгээр					
1	Ахмадын төвийн барилга Баянзүрх сум Багц -1	365.6	248.5	117.1	МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл үндэслэн дуусгалын гэрээ байгуулсан
2	Ахмадын төвийн барилга Цагаан-Үүр сум Багц-2	521.6	239.9	281.7	
3	Ахмадын төвийн барилга Чандмань-Өндөр сум Багц-3	526.8	245.1	281.7	
4	Нийтийн ариун цэврийн байгууламжийн дуусгал /Хөвсгөл, Мөрөн сум/	200.0	140.0	-	Хуулиар нэмэлт дуусгалын ажлын төсөв баталсан
Нийт		1614.0	873.5	680.5	
Нийт дүн		5,573.0	3,822.5	1,690.5	

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ашиглаж эхлээгүй байгаа хөрөнгө оруулалтын жагсаалт

№	Төсөл арга хэмжээ	Ашиглахгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн нэр	Ашиглалтад авсан огноо	Бүртгэлд тусгасан дүн	Тайлбар
Барилга байгууламж					
1	Нийтийн ариун цэврийн байгууламжийн дуусгал	Нийтийн ариун цэврийн байгууламж	2022.07.22	139.9	Ашиглаж эхлээгүй.
Тоног төхөөрөмж					
1	Бизнес хөгжлийн төвийн тоног төхөөрөмж	Бизнес хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Ширээ сандал, техник хэрэгсэл, компьютер, хэвлэгч/	2022.05.12	29.2	УТХО-р баригдаж буй Бизнес хөгжлийн төв ашиглалтад ороогүй.
2	Жижиг, дунд оврын усалгааны систем	Жижиг, дунд оврын усалгааны систем /Хөвсгөл, Галт, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Рашаант, Эрдэнэбулган, Түнэл, Жаргалант сум/	2022.12.15	94.1	Биетээр ХХААГ дээр хадгалж байна.
3	Орон нутгийн үйлдвэрлэлийг	Багц-1 Хүнсний ногоо даршлах тоног төхөөрөмж	2022.12.16	96.2	Агуулахад хадгалж байна.

4	дэмжих тоног төхөөрөмж	Багц-2 Газар тариаланд ашиглах дугуйт трактор, тоног төхөөрөмжийн иж бүрдэл	2022.09.04	198.5	Ашиглаж эхлээгүй байна.
5	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл	Багц-6 Газар тариалангийн зориулалттай трактор, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл	2022.07.25	376.58	Газар тариалангийн тариалантын хугацаанаас хойш ирсэн учир хуваарилаагүй.
6		Багц-7 ашиглалтын зардал багатай эрчим хүч, шатахуун зарцуулдаггүй эдийн засгийн хэмнэлттэй, инновацын шийдэлтэй, голоос тариалангийн талбай руу ус шахах услалтын систем	2022.08.25	148.9	
7		Багц-8 газар хадлангийн нөөц бүрдүүлэх, ногоон тэжээл тариалах иж бүрдэл, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл	2022.11.07	1604.8	
8		Багц-13 цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж	2022.09.23	10.5	
9		Багц-14 дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны /6*10/ хэмжээтэй хүлэмж	2022.12.21	44.4	Агуулахад хадгалж байна.
10		Багц-15 дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны /6*10/ хэмжээтэй хүлэмж	2022.12.21	59.2	
11	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл	Багц-9 арьс шир боловсруулах тоног төхөөрөмж	2022.08.25	51.0	127.5 сая төгрөгийн 5 ш тоног төхөөрөмжөөс 2-г хадгалж байна.
12		багц-11 дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны /20*8/ хэмжээтэй хүлэмж	2022.05.30	154.5	321.9 сая төгрөгийн 50 ш тоног төхөөрөмжөөс 24-г хадгалж байна.
Нийт дүн				3,007.8	

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл

№	Төсвийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 50 жилийн үндсэн чиглэл	Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	Хөвсгөл аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө
1	1.9	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	14.4	6.2.1.1	6.2.2	6.3.1	5.6.3	5.1.13
2	Хуучин төсөв 2.1	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах тоног төхөөрөмжөөр хангах	90.0	5.4.1.4	5.4.4	5.3.6	4.2.6	4.2.2
3	2.1	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах /Мөрөн сум/	156.5	5.4.1.4	5.4.4	5.3.6	4.2.6	4.2.2, 6.1.11
4	Хуучин төсөв 2.2	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин, тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах	49.4	4.1.1.2	4.1.2	4.2.9	3.1.20	3.1.12
5	2.2	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0	9.1.1.2	9.1.1	2.1.8	2.3.9, 2.3.10	2.3.15
6	2.3	Уурын зуухны буулгалтын зардал/Титэм сургуулийн зүүн талын уурын зуухны барилга/	49.2	3.6.1.3	3.6.3	8.1.2	3.10.2	
7	2.4	Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга худалдан авах /Мөрөн сум 8-р баг/	119.4	2.5.1.2	2.5.3	8.1.7	5.3.4	3.6.7
8	2.5	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0	2.5.2	2.5.2	8.1.2	3.10.10	
9	2.6	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0	2.5.2	2.5.2	8.1.2	3.10.10	
10	2.7	Мод тарьж, ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа, хайс барих, шинэчлэх /Мөрөн сум 5 дугаар баг / - багц 1	500	2.5.1.2	2.5.3	6.2.3	5.3.3	5.1.10
11	2.8	Төв суурингийн орчимд хамгаалалтын зурвас байгуулах ажлын хүрээнд Мөрөн сумын зарим ногоон байгууламж нэмэгдүүлэх	20.0	2.5.1.2	2.5.3	6.2.3	5.3.3	5.1.10
12	2.9	Хатуу хучилттай авто замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах /Мөрөн сум төв зам/	20.0	3.4	8.1.3	8.2.1	3.9.2	3.5.2
13	2.10.	Гудамж албайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт/Мөрөн сум/ - Багц 1 - Гудамж талбайн гэрэлтүүлэгийн засвар арчлалт//Мөрөн сум/	20.0	9.2.40	9.2	8.1.2	3.10.2	
14	2.11	Баяр наадмын талбайн засварын "Үзэгчдийн шаталсан суудал солих, засварлах"/Мөрөн сум/	40.0	1.5.12	1.5.3	1.1.2	2.9.2	3.6.7
15	2.12	Аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан	28.9	6.3.1.4	6.3.4	6.1.3	5.7.2, 5.7.3	5.1.11

		байгуулах технологийн шийдэл /Хөвсгөл ус суваг ХХК/						
16	2.13	Хог хаягдлын эх үүсвэр дээр нь ангилан ялгалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хог пресслэх тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум/	70.0	9.2.1.4	9.2.2	6.5.4	5.4.1	5.1.19
17	2.14	Загас үржүүлгийн цөөрмийн загасны аж ахуй байгуулах ажлын хүрээнд Цагаан загас үржүүлэх аппарат худалдан авах /Цагааннуур сум/	20.0	6.2.1.1	6.2.2	6.3.1	5.6.3	5.1.13
18	2.15	Нийтийн зориулалттай орон сууцны узель, шугам сүлжээг шинэчлэх ажил/Мөрөн сум 8 дугаар баг, 18 дугаар байр/	68.4	2.5.2	2.5.2	8.1.2	3.10.10	
19	2.16	Газар чөлөөлөх Г байрыг буулгах /Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/Мөрөн сум	19.8	3.6.1.3	3.6.3	8.1.2	3.10.2	
20	2.17	Мөрөн сумын 14 дүгээр багийн ард камер тавих ажил /Нисэхийн аюулгүй байдлыг хангах/	5.5	8.1.1.6	8.1.6	8.2.2	3.9.1	4.3.3
21	2.18	Аймгийн НЭ-ийн амбулаторийн урд авто зам дагуу авто, зогсоол, явган хүний замын ажил /Мөрөн сум/	97.5	2.2.1.4	2.2.4	2.2.8	2.1.11	2.1.13
22	2.19	10 дугаар багт хашаа хайс, ногоон байгууламж нэмэгдүүлэх /Мөрөн сум/	35.0	2.5.1.2	2.5.3	6.2.3	5.3.3	5.1.10
23	2.20.	Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх /Мөрөн сум/	39.3	2.1.1.2	2.1.8	2.1.8	2.3.10	2.3.15
24	2.21	Морь барианы газарт нойл барих /Мөрөн сум/	20.0	2.5.1.2	2.5.3	8.1.7	5.3.4	3.6.7
25	2.22	Баяр наадмын талбайн гадна талбайн тохижилт, засвар /Мөрөн сум/	34.7	1.5.12	1.5.3	1.1.2	2.9.2	3.6.7
26	Хавсралт 5-ын 1	Аймгийн ЗДТГ-ын байрны их засвар	1,037.4	5.4.1.4	5.4.4	5.3.6	4.2.6	4.2.1
27	Хавсралт 5-ын 2	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн засварын ажил	300.0	2.2.1.4	5.4.4	2.2.8	2.1.11	2.1.13

ТЕЗ-ийн Худалдан авах ажиллагааны тайланд зөрүүтэй мэдээлсэн мэдээлэл

д/д	Зөрчлийн утга	Зөрчсөн хууль, тогтоомж	Зөрчлийн дүн /сая төгрөг/
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаж, ХАА-ны эрх шилжсэн 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээллийг ТЕЗ-ийн тайланд нэгтгээгүй	Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 4.2	94.5
2	Гүйцэтгэгч шалгараагүй сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний ХАА-ны тайланд тусгаагүй,	Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 4.5	68.4
3	Мод тарьж, ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа, хайс барих, шинэчлэх /Мөрөн сум 5 дугаар баг / - багц 1 ажлын гэрээний үнийн дүнг 2.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 49 дүгээр зүйлийн 49.5	2.3
4	Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх /Мөрөн сум/ ажлын гэрээний үнийн дүнг 0.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 49 дүгээр зүйлийн 49.5	0.3
Нийт			165.5

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2022 онд санхүүж их дүн	Гүйцэтгэгч	Гэрээн ий дүн	Санхү үжилт
1	АЗДТГ-ын барилгын байрны 3 давхрын засварын ажлын дуусгалт	55.2	10.0	Хөх тэнгэр Хөвсгөл ХХК	55.0	10.0
2	Спорт заалны барилга шинээр барих, барилга угсралтын ажлын дуусгалт /Эрдэнэбулган сум/	197.5	52.0	Хөвсгөл мон трейвел ХХК	64.1	52.0
3	Аймгийн "Авто зам"-ыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөрөн сумын хатуу хучилттай зам барих /Нэгдсэн эмнэлгийн урд уулзвараас ДЦС өнгөртөл -1.6 км/	850.0	399.5	Хүслэнт бүтээмж ХХК	849.5	399.5
4	Спорт заалны барилга /Шинэ-Идэр сум/	950.0	100.0	Идэр нумт ХХК	950.0	100.0
5	Аврах анги барих /Галт сум/	201.0	94.0	Агар эрдэнэс трейд ХХК	201.0	94.0
6	Баяр наадмын талбайн урд асрын засвар /Мөрөн сум/	229.4	209.4	Бунбах ХХК	224.9	204.9
7	Хөгжимт драмын театрын дээврийн засвар /Мөрөн сум/	100.0	30.0	Эндус эрхэт ХХК	90.6	20.6
8	Нэгдсэн эмнэлгийн өндөр хүчдэлийн хуваарилах байгууламжийн барилгын дээврийн засвар	50.0	9.5	Хөх гүрэн констракшн ХХК	49.5	9.5
9	Цагааннуур суманд цагаан загас үржүүлгийн судалгааны байр барих	14.4	14.4	Булган тамга ХХК	14.4	14.4
10	Гэрлэн чимэглэл хийх/Мөрөн сум/	79.3	19.6	Хөвсгөл эрмүүн оч ХХК	79.3	19.6
11	Хоймор нутгийн чулуу ХХК-ийн хэвийн үйл ажиллагааг хангах, орон нутгийн өмч төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, түүхий эдийн нөөц бүрдүүлэх, тогтоох, хайгуул хийх ажлын зөвлөх үйлчилгээ	40.0	2.0	Цогт очир инженеринг ХХК	40.0	2.0
12	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах тоног төхөөрөмжөөр хангах	90.0	90.0	Голден хоул ХХК	83.7	83.7
13	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгад дулааны шугам татах /Мөрөн сум/	156.5	100.0	Туурайн тамга ХХК	153.5	90.6
14	Орон нутгийн хөрөнгөөр бий болсон машин, тоног төхөөрөмжийг хадгалах байр засварлах	49.4	49.4	Хөвсгөл булаг ХХК	49.4	48.2
15	Цэцэрлэгийн гал тогооны засвар /Хатгал тосгон/	50.0	40.0			
16	Уурын зуухны буулгалтын зардал/Титэм сургуулийн зүүн талын уурын зуухны барилга/	49.2	49.2	Хөх Монгол констракшн ХХК	49.2	49.2
17	Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга худалдан авах /Мөрөн сум 8-р баг/	119.4	119.4	Уул-Өвгөд ХХК	119.4	119.4
18	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 15-р байр/	100.0	100.0	Бунбах ХХК	100.0	92.8
19	Нийтийн зориулалттай орон сууцны дээврийн их засвар /Мөрөн сум 8 баг 16-р байр/	90.0	90.0	Бунбах ХХК	90.0	90.0
20	Төв суурингийн орчимд хамгаалалтын зурвас байгуулах ажлын хүрээнд Мөрөн сумын зарим ногоон байгууламж нэмэгдүүлэх	20.0	20.0	Мөрөн ХТҮТөв ХХК	20.0	20.0
21	Хатуу хучилттай авто замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах /Мөрөн сум төв зам/	20.0	20.0	Хөвсгөл зам ХХК	20.0	20.0
22	Гудамж талбайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт/Мөрөн сум/ - Багц 1 - Гудамж талбайн гэрэлтүүлгийн засвар арчлалт//Мөрөн сум/	20.0	20.0	Бархадай ХХК	20.0	20.0
	Гудамж талбайн гэрэлтүүлэг, индрийн засвар арчлалт/Мөрөн сум/ - Багц 2 - Чингүнжавын талбайн индрийн засвар арчлалт/Мөрөн сум/	10.0	10.0	Хөвсгөл мичид ХХК	10.0	10.0
23	Баяр наадмын талбайн засварын "Үзэгчдийн шаталсан суудал солих, засварлах"/Мөрөн сум/	40.0	40.0	"Ди Ти И Эм строй" ХХК	40.0	40.0

24	Аймгийн төв болон сум, суурин газрын ундны усны чанарын судалгаа, мэдээллийн сан байгуулах технологийн шийдэл /Хөвсгөл ус суваг ХХК/	28.9	28.9	Хөвсгөл ус суваг ХХК	28.9	28.9
25	Хог хаягдлын эх үүсвэр дээр нь ангилан ялгалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хог пресслэх тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум/	70.0	70.0	Эф Ай Эф Өү ХХК	49.2	49.2
26	Загас үржүүлгийн цөөрмийн загасны аж ахуй байгуулах ажлын хүрээнд Цагаан загас үржүүлэх аппарат худалдан авах /Цагааннуур сум/	20.0	20.0	Шинэ Сариг ХХК	20.0	20.0
27	Газар чөлөөлөх Г байрыг буулгах /Дэлгэрмөрөн цогцолбор сургууль/Мөрөн сум	19.8	19.8	Сант-Өндөр ХХК	19.8	19.5
28	Мөрөн сумын 14 дүгээр багийн ард камер тавих ажил /Нисэхийн аюулгүй байдлыг хангах/	5.5	5.5	Гүргэн нутаг ХХК	5.5	5.5
29	10 дугаар багт хашаа хайс, ногоон байгууламж нэмэгдүүлэх /Мөрөн сум/	35.0	35.0	Баяндэ ХХК	34.0	33.0
30	Эрдмийн далай цогцолбор сургуулийн А, Б хичээлийн хуучин байранд засвар хийх /Мөрөн сум/	39.3	39.3	Голден прогресс ХХК	39.3	39.3
31	Морь барианы газарт нойл барих /Мөрөн сум/	20.0	20.0	Баясах гал ХХК	20.0	20.0
32	Баяр наадмын талбайн гадна талбайн тохижилт, засвар /Мөрөн сум/	34.7	34.7	Бунбах ХХК	27.3	27.3
33	Аймгийн ЗДТГ-ын байрны их засвар	1,037.4	250.6	Бунбах ХХК	238.9	238.9
34	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн засварын ажил	300.0	300.0	Хөвсгөл мичид ХХК	297.6	285.6
Нийт		5,858.7	2,979.2		4,643.5	2,377.6

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн боловч одоог хүртэл дуусаагүй барилга байгууламжийн зураг

<p>Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилга</p>	
<p>Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга</p>	 
<p>Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга</p>	